



**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

"Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Газрын тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.2.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын газрын даамал нарт, хэрэгжилтийг ханган хяналт тавьж ажиллахыг Кадастрын хэлтэс /П.Баянтүмэн/-т тус тус даалгасугай.
- 3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/-ын даргын 2008 оны 83 дугаар тушаал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/220 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.ГАНХҮҮ